ГААЛЬ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 02 дугаар сарын 24-ны өдөр | Дугаар А/41 | Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.7 дахь хэсэг, Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 1 дүгээр,
“Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 2 дугаар,
“Барааг хилийн чанадад боловсруулах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 3 дугаар,
“Барааг хилийн чанадад буцаан гаргах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 4 дүгээр хавсралтын ёсоор баталсугай.

2.Энэ тушаалын биелэлтийг зохион байгуулж, харьяа гаалийн газар, хороодыг удирдамж чиглэлээр хангаж ажиллахыг Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн газар /Б.Батгэрэл/-т үүрэг болгосугай.

3.Шинэчлэн батлагдсан гаалийн бүрдүүлэлтийн горимын кодыг CAIS системийн ангилалтын санд оруулахыг Мэдээллийн технологийн төв /Ш. Батзаяат/-д даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Гааль, татварын ерөнхий газрын даргын 2008 оны 677, 2009 оны 363, 2011 оны 254, 2015 оны А/106, А/189, А/285 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА С. ПҮРЭВ

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 3620 дугаарт бүртгэсэн.

Гааль, татварын ерөнхий газрын даргын
2016 оны А/41 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

БАРААГ ХИЛИЙН ЧАНАДАД БҮРМӨСӨН ГАРГАХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Бараг хилийн чанадад бүрмөсөн гаргах гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 115-118 дугаар зүйл, цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд гаалийн тухай хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.

1.2. Бараг хилийн чанадад бүрмөсөн гаргах горим сонгох, бичиг баримт бүрдүүлэх, татвар, хураамж ногдуулах, төлөх, хураан авах, бараг горимд байршуулах, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлага хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр бараг уг горимд байршуулна.

1.4. Горимын дагуу шаардагдах бичиг баримт, гаалийн үнийг үндэслэн ногдуулсан экспортын болон бусад татварыг бүрэн төлсөн тохиолдолд монголын бараг хилийн чанадад бүрмөсөн гаргана.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1. Горимд гаалийн тухай хуулийн 116 дугаар зүйлд заасан бараг байршуулна.

2.2. Энэ журмын 2.1-д заасан бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарна.

2.3. Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

Горимын утга		Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын бараг хилийн чанадад бүрмөсөн гаргах	100	шаардахгүй
2	Олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гаалийн болон бусад татвараас чөлөөлж хилийн чанадад бүрмөсөн гаргах	101	шаардахгүй
3	Монгол банкнаас гадаадад		

	цэвэршүүлэхээр гаргаж байгаа алт / төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэйгээр/ болон онцгой албан татварын тэмдэгт	110	шаардахгүй
4	Хилийн чанадад түр хугацаагаар гаргасан барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах	120	200,210
5	Хилийн чанадад боловсруулах горимд байршуулсан монголын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах:		
	-тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулахаар	131	201,211
	-тухайн бараагаар шинэ бүтэгдэхүүн үйлдвэрлэхээр	132	202,212
	-тухайн бараанд засвар хийхээр	133	203,213
	-тухайн барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглахаар	134	204,214
6	Гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан монголын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах:		
	- гаалийн баталгаат агуулахаас	141	701,702
	- гаалийн баталгаат үйлдвэрийн газраас	142	711
	- гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас	143	721
	- гаалийн тусгай бүсээс	144	754-757
	- татваргүй барааны дэлгүүрээс	145	741
7	Чөлөөт бүсийн горимд байршуулсан монголын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах	150	772,773
8	Бүртгэл, зорчигчийн гаалийн мэдүүлгээр хилийн чанадад түр хугацаагаар гаргасан монголын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах:		
	-тээврийн хэрэгслийн бүртгэлд бүртгэсэн тээврийн хэрэгсэл	160	Бүртгэлийн №
	-АТА карнейтэй бүртгэгдсэн	161	Нотолгооны №
	-СПД карнейтэй бүртгэгдсэн	162	Нотолгооны №
	-зорчигчийн барааны гаалийн	163	Зорчигчийн

	мэдүүлэгтэй		барааны ГМ

Гурав. Бичиг баримт

3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараах бичиг баримтыг шаардана.

3.1.1. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх, гадаад төлбөр тооцооны баримт;

3.1.2. тээврийн бичиг баримт / тээврийн баримт, баглаа боодлын жагсаалт, техникийн бичиг баримт гэх мэт/;

3.1.3. гарал үүслийг нотлох баримт;

3.1.4. эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, лиценз, сертификат;

3.1.5. гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх бол түүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагын баримт;

3.1.6. лабораторийн шинжилгээний дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/;

3.1.7. шаардлагатай бусад бичиг баримт.

3.2. Мэдүүлэгч 3.1-д заасан бичиг баримтыг электрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.3. Журмын 3.1-д заасан мэдээлэл, баримт бичиг нь горимын шаардлага хангахгүй байвал гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.4. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Монголын гааль зөвшөөрөв” хяналтын тэмдэг дарна.

Дөрөв. Горимын шаардлага

4.1. Хилийн чанадад бүрмөсөн гаргах бараанд гаалийн болон бусад татварыг ногдуулах бөгөөд энэ нь гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх бараанд нэгэн адил хамаарна.

4.2. Гаалийн байгууллага горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн экспортын барааны гаалийн үнийг нягтлан шалгаж, тухайн бараа экспортын татвартай бол гаалийн болон бусад татварыг ногдуулан хураан авч төсөвт төвлөрүүлнэ.

4.3. Экспортын татвартай бараанд гаалийн болон бусад татвар бүрэн төлсөн, эсхүл Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2-т зааснаар татвар төлөх баталгааг гаргасан тохиолдолд гаалийн бүрдүүлэлт хийнэ.

4.4. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд бараг байршуулахаас татгалзана.

4.5. Чөлөөт эргэлтэд орсон гадаадын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргахад урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.

Тав. Бусад

5.1. Барааг улсын хилээр гаргаснаар горим дуусгавар болно.

5.2. Горимд байршуулсан бараа нь гаалийн зөрчлийн улмаас саатуулагдсан, хураагдсан бол горимын үйлчлэл дуусгавар болно.

---oOo---

Гааль, татварын ерөнхий газрын даргын
2016 оны А/41 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

БАРААГ ХИЛИЙН ЧАНАДАД ТҮР ХУГАЦААГААР ГАРГАХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 119-124 дүгээр зүйл, цаашид "горим" гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.

1.2. Монголын бараанд өөрчлөлт оруулахгүйгээр хугацаанд нь буцаан оруулах нөхцлөөр гаалийн нутаг дэвсгэрээс түр хугацаагаар хилийн чанадад гаргах горим сонгох, бичиг баримт бүрдүүлэх, татвар, хураамж ногдуулах, төлөх, хураан авах, барааг горимд байршуулах, горим дуусгавар болохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.

1.4. Энэ горимд байршуулах барааг гаалийн хяналтад байх нөхцөлтэйгээр хилийн чанадад түр хугацаагаар гаргана.

1.5. Түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдворыг хилийн чанадад түр хугацаагаар гаргахад Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.4 дэх заалтын хугацааг баримтална.

1.6. Түр хугацаагаар гаргах горимд дараах барааг байршуулахыг хориглоно: хүнсний бараа /ус, ундаа, согтууруулах ундаа/, тамхи болон тамхины зүйл, дээж, түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хаягдал, түр горимд байрших хугацаанд уусаж, устах бараа.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1. Горимд гаалийн тухай хуулийн 120 дугаар зүйлд заасан барааг байршуулна.

2.2. Энэ журмын 2.1-д заасан бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарна.

2.3. Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг хилийн чанадад түр гаргах	200	шаардахгүй
2	Хилийн чанадад түр хугацаагаар	210	200

	гаргасан барааны хугацааг Гаалийн тухай хуулийн 123.2-т заасны дагуу сунгах		

Гурав. Горимын дагуу шаардагдах бичиг баримт

3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараах бичиг баримтыг шаардана.

3.1.1. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх, төлбөр тооцооны баримт;

3.1.2. тээврийн бичиг баримт /тээврийн баримт, баглаа боодлын жагсаалт, техникийн бичиг баримт гэх мэт/;

3.1.3. гарал үүслийг нотлох баримт;

3.1.4. эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, лиценз, сертификат;

3.1.5. гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх бол түүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагын баримт;

3.1.6. лабораторийн шинжилгээний дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/;

3.1.7. шаардлагатай бусад бичиг баримт.

3.2. Мэдүүлэгч 3.1-т заасан бичиг баримтыг электрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.3. Журмын 3.1-т заасан мэдээлэл, баримт бичиг нь горимын шаардлага хангахгүй байвал гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.4. Гаалийн байгууллага Гаалийн тухай хуулийн 123.2-т зааснаар уг горимын хугацааг сунгасан тохиолдолд шинээр гаалийн мэдүүлэг бичүүлж, горимын 210 кодоор бүрдүүлэлтийг хийнэ.

3.5. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Гаалийн хяналтад байгаа” хяналтын тэмдэг дарна.

Дөрөв. Горимын шаардлага

4.1. Хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимын дагуу шаардагдах бичиг баримтыг үндэслэн монголын бараанд өөрчлөлт оруулахгүйгээр хугацаанд нь буцаан оруулах нөхцлөөр барааг гаргана.

4.2. Гаалийн байгууллага нь энэ горимд байршуулах бараанд гаалийн бүрдүүлэлт хийхдээ гаалийн тэмдэглэгээ тавих, марклах, сорьц, дээж, загвар авах, бараа, тээврийн хэрэгслийн шинж байдлыг дэлгэрэнгүй тодорхойлон бичих, фото зураг авах, бичлэг хийх, бүдүүвч зураг гаргах зэрэг аргыг хэрэглэж файл үүсгэн хадгалж, барааг гаалийн хилээр буцаан оруулахад гаргасан гаалийн мэдүүлэг болон гаалийн зорилгоор хийсэн дээрх тэмдэглэгээг нэг бүрчлэн шалгаж мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулна.

4.3. Энэ журмын дагуу барааг тогтоосон хугацаанд буцаан оруулаагүй тохиолдолд тусгай дансанд байршуулсан гаалийн болон бусад татварыг

төсвийн орлогын дансанд шилжүүлэх тухай хавсралтаар батлагдсан загвар бүхий баталгаа гаргуулан, гаалийн мэдүүлэгт хавсаргана.

4.4.Барааг түр хугацаагаар гаргах талаар гаалийн байгууллагад баталгаа гаргасан этгээд нь гаалийн байгууллагын өмнө хуульд заасан үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4.5.Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд барааг байршуулахаас татгалзана.

4.6.Хилийн чанадад түр хугацаагаар гаргах бараанд хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын ердийн нөхцөлд гарах элэгдэл, хорогдлоос бусад өөрчлөлт оруулахыг хориглоно.

4.7.Хилийн чанадад түр хугацаагаар гаргасан барааны хэрэглээний чанарыг хадгалах зорилгоор үйлчилгээ хийж болно.

4.8.Чөлөөт эргэлтэд оруулсан гадаадын барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргахад урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.

4.9. Хилийн чанадад түр хугацаагаар гаргах гаалийн бүрдүүлэлтийн горимын барааг анх гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага хяналт тавьж, тусгай бүртгэл хөтлөн, хугацаа дуусахад бусад горимд шилжүүлэн гаалийн бүрдүүлэлт хийж, хаалтын мэдээг сар бүр Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох хэлтэст ирүүлнэ. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас яаралтай тодруулах зорилгоор мэдээ тайлан гаргаж өгөхийг шаардсан тохиолдолд хугацаанд нь биелүүлнэ.

Тав. Гаалийн бүрдүүлэлтийн горимд мөрдөх баталгаа

5.1. Барааг хилийн чанадад түр гаргахад тухайн бараа нь экспортын татвартай бол татварыг ногдуулан хураан авч, түр дансанд төвлөрүүлэх, эсхүл Гаалийн тариф, гаалийн татварын тухайн хуулийн 41.2-т зааснаар татвар төлөх баталгааг гаргуулан авч болно.

5.2. Түр хугацаагаар гаргасан барааг тогтоосон хугацаанд буцаан оруулаагүй, эсхүл хугацаа сунгуулаагүй бол зохих горимоор гаалийн бүрдүүлэлт хийж, түр дансанд төвлөрүүлсэн гаалийн болон бусад татварыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

5.3. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2-т заасан баталгааг гаргаж түр хугацаагаар хилийн чанадад гаргасан барааг буцаан оруулаагүй тохиолдолд гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлнэ.

---oOo---

Гааль, татварын ерөнхий газрын даргын
2016 оны А/41 дугаар тушаалын 2
дугаар хавсралтаар батлагдсан
журмын хавсралт

БАТАЛГАА

20 ... оны ... дугаар сарын ... өдөр

_____
_____
/татвар төлсөн ААН, байгууллага, иргэний нэр, регистрийн №/
гаалийн хилээр түр хугацаагаар гаргасан барааг Гаалийн тухай хуулийн _____ дугаар зүйлд заасан хугацаанд буцаан оруулаагүй эсхүл өөр горимд шилжүүлээгүй тохиолдолд _____дугаар гаалийн мэдүүлгээр гаалийн болон бусад татварт төлсөн_____төгрөг_____
_____
_____
/ татварын дүн үсгээр /
төгрөгийг төрийн сангийн тусгай данснаас улсын төсөвт үл маргах зарчмаар шилжүүлэхийг зөвшөөрч байна.

БАТАЛГАА ГАРГАСАН:

....
/Албан тушаалын нэр, /гарын үсэг/ /Албан тушаалтны нэр/
Тамга, тэмдэг/

Гааль, татварын ерөнхий газрын даргын
2016 оны А/41 дугаар тушаалын
3 дугаар хавсралт

БАРААГ ХИЛИЙН ЧАНАДАД БОЛОВСРУУЛАХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барааг хилийн чанадад боловсруулах гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 125-131 дүгээр зүйл, цаашид “горим”гэх/-ыг хэрэгжүүлэхэд гаалийн тухай хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.
1.2. Горим сонгох, барааг горимд байршуулах, бичиг баримт бүрдүүлэх, татвар, хураамж ногдуулах, төлөх, хураан авах, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.
1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.
1.4. Горимд байршуулсан барааг гаалийн байгууллагын зөвшөөрснөөс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.
1.5. Түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдворыг хилийн чанадад боловсруулахаар гаргахад Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.4 дэх заалтын хэсэгт заасан хугацааг баримтална.
1.6. “Засвар хийх” гэдэгт дараах үйл ажиллагаа хамаарна:
- тухайн барааны эвдэрч гэмтсэн хэсгийг засах,
- шинэчлэх,
- дутуу хэсгийг нөхөн гүйцээх, эсхүл
- барааг БТКУС-ийн ангиллын кодын 8 оронгийн түвшинд ижил төрлийн өөр бараагаар солих.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1. Горимд гаалийн тухай хуулийн 126 дугаар зүйлд заасан барааг байршуулна:
2.2. Энэ журмын 2.1-д заасан бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарна.
2.3. Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг хилийн чанадад боловсруулах:		

	- барааг боловсруулах, эсхүл баяжуулах - тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх - засвар хийх - барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах	201 202 203 204	шаардахгүй
2	Хилийн чанадад боловсруулах горимоор гарсан барааны хугацааг сунгах:		
	- барааг боловсруулах, эсхүл баяжуулах - тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх - засвар хийх - барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах	211 212 213 214	201 202 203 204

Гурав. Бичиг баримт

3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараах бичиг баримтыг шаардана.

3.1.1.гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх, гадаад төлбөр тооцооны баримт;

3.1.2. тээврийн бичиг баримт / тээврийн баримт, баглаа боодлын жагсаалт, техникийн бичиг баримт гэх мэт/;

3.1.3. гарал үүслийг нотлох баримт;

3.1.4. эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, лиценз, сертификат;

3.1.5. гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх бол түүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагын баримт;

3.1.6. лабораторийн шинжилгээний дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/;

3.1.7. шаардлагатай бусад бичиг баримт.

3.2. Мэдүүлэгч 3.1-д заасан бичиг баримтыг электрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.3. Журмын 3.1-д заасан мэдээлэл, бичиг баримт нь горимын шаардлага хангахгүй байвал гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.4. Гаалийн байгууллага Гаалийн тухай хуулийн 130.2-т зааснаар уг горимын хугацааг сунгасан тохиолдолд шинээр гаалийн мэдүүлэг бичүүлж, горимын 211-214 кодоор бүрдүүлэлтийг хийнэ.

3.5. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Гаалийн хяналтад байгаа” хяналтын тэмдэг дарна.

Дөрөв. Горимын шаардлага

4.1. Мэдүүлэгч нь барааг хилийн чанадад боловсруулах горимд байршуулахдаа бараа боловсруулахтай холбогдсон бүхий л мэдээллээр гаалийн байгууллагыг хангана. Тухайлбал: боловсруулах барааны нэр, марк, серийн дугаар, материалын орцын тооцоо, хаягдал, үлдэгдлийн хэмжээ, боловсруулалтын үр дүнд бий болсон бүтээгдэхүүний загвар, дээж, фото зураг, бүдүүвч зураг, худалдааны болон техникийн бичиг баримт, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлт, өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэх бол тухайн бүтээгдэхүүний мэдээлэл, схем, фото зургийг хавсаргана.

4.2. Энэ горимын дагуу боловсруулалт хийхэд дараахь шаардлага хангасан байна:

4.2.1. тухайн барааны боловсруулалтад гаалийн байгууллага хяналт тавих боломжтой байх;

4.2.2. гаалийн байгууллага тухайн барааг оролцуулан боловсруулсан бүтээгдэхүүнд гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийх боломжтой байх;

4.2.3. гадаад худалдааны гэрээнд барааг боловсруулах арга, үе шат, хугацаа, ямар засвар, өөрчлөлт оруулах, шинээр ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах, зэрэг боловсруулалтын үйл ажиллагааны тухай нарийвчлан тусгасан байх;

4.2.4.гадаадын барааг монголын бараатай нийлүүлж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, монголын барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах бол материалын орцын норм хэмжээг тогтоосон байх**.**

4.2.5. солих бараа нь БТКУС-ийн ангиллын кодын 8 оронгийн түвшинд ижил байх бөгөөд тухайн барааны чанар, техникийн үзүүлэлт нь засварт гаргах үйлдвэрийн болон материалын доголдолтой бараатай адил байна. Доголдол илэрсэн барааг солихоор гаргах түр хугацаа нь тухайн барааг анх дотоодын хэрэглээнд зориулан оруулсан өдрөөс хойш 6 сарын дотор байна.

4.2.6. үйлдвэрийн болон материалын доголдолтой, ашиглалтад байсан барааг өөр бараагаар сольж хилийн чанадаас оруулах тохиолдолд орлуулах бараа нь мөн адил ашиглагдсан хуучин бараа байна.

4.2.7. гаалийн байгууллагын тавьсан нөхцөл, шаардлагын дагуу, холбогдох этгээд доголдолтой барааг хилээр гаргахаас өмнө солих бараа бүтээгдэхүүнийг гаалийн хилээр оруулж ирж болно.

4.2.8. солих бараа бүтээгдэхүүнийг хилээр гаргах боломжгүй бол төлбөл зохих импортын татварын үнийн дүнгээр баталгаа гаргасан байх ба гаалийн болон бусад татварыг ногдуулж төлүүлнэ.

4.3. Хэрвээ мэдүүлэгч нь энэ журмын 4.1, 4.2-т заасан шаардлагыг хангаагүй, боловсруулалтын үйл ажиллагаа тодорхой бус байх тохиолдолд гаалийн байгууллага нь тухайн горимд барааг байршуулахаас татгалзаж энэ тухайгаа мэдүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.

4.4. Гаалийн байгууллага нь энэ горимд байршуулсан бараанд Гаалийн тухай хуулийн 261.1-д заасан гаалийн тэмдэглэгээнээс аль тохирохыг хэрэглэнэ.

4.5. Барааг хилийн чанадад боловсруулалт хийх горимоор гаалийн бүрдүүлэлт хийхэд тухайн бараа нь экспортын татвартай бол татварыг ногдуулан төлүүлж түр дансанд байршуулах, эсхүл төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2-т заасны дагуу гаргасан байна.

4.6. Энэ журмын дагуу барааг тогтоосон хугацаанд буцаан оруулаагүй тохиолдолд тусгай дансанд байршуулсан гаалийн болон бусад татварыг төсвийн орлогын дансанд шилжүүлэх тухай хавсралтаар батлагдсан загвар бүхий баталгаа гаргуулан, гаалийн мэдүүлэгт хавсаргана

4.7. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийж гаргасан бараа тогтоосон хугацаанд нь буцаан оруулаагүй тохиолдолд хилийн чанадад бүрмөсөн гаргах горимоор гаалийн бүрдүүлэлтийг хийнэ.

4.8. Барааг түр хугацаагаар гаргах талаар гаалийн байгууллагад баталгаа гаргасан этгээд нь гаалийн байгууллагын өмнө хуульд заасан үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4.9. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд барааг байршуулахаас татгалзана.

4.10. Хилийн чанадад боловсруулах горимд байршуулсан барааг анх гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага хяналт тавьж, тусгай бүртгэл хөтлөн, хугацаа дуусахад бусад горимд шилжүүлэн гаалийн бүрдүүлэлт хийж, хаалтын мэдээг бүр Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох хэлтэст ирүүлнэ. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас яаралтай тодруулах зорилгоор мэдээ тайлан гаргаж өгөхийг шаардсан тохиолдолд хугацаанд нь биелүүлнэ.

Тав. Гаалийн бүрдүүлэлтийн горимд мөрдөх баталгаа

5.1. Мэдүүлэгч нь барааг хугацаанд нь буцаан оруулаагүй, хугацаа сунгуулаагүй байх тохиолдолд гаалийн байгууллага энэ журмын 4.6-д заасан баталгааг үндэслэн тусгай дансанд төвлөрүүлсэн гаалийн болон бусад татварыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

5.2. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2-т заасан баталгааг гаргаж түр хугацаагаар хилийн чанадад гаргасан барааг буцаан оруулаагүй тохиолдолд гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлнэ.

5.3. Чөлөөт эргэлтэд орсон гадаадын барааг хилийн чанадад боловсруулалт хийхэд урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.

Зургаа. Бусад

6.1. Барааг хилийн чанадад боловсруулах горим нь уг барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулснаар, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.

6.2. Горимд байршуулсан бараа нь гаалийн зөрчлийн улмаас саатуулагдсан, хураагдсан бол горимын үйлчлэл дуусгавар болно.

Гааль, татварын ерөнхий газрын даргын
2016 оны А/41 дугаар тушаалын
3 дугаар хавсралтаар батлагдсан
журмын хавсралт

БАТАЛГАА

20 ... оны ... дугаар сарын ... өдөр

_____
_____
/татвар төлсөн ААН, байгууллага, иргэний нэр, регистрийн №/
гаалийн хилээр хилийн чанададад боловсруулахаар гаргасан барааг Гаалийн тухай хуулийн _____дугаар зүйлд заасан хугацаанд буцаан оруулаагүй эсхүл өөр горимд шилжүүлээгүй тохиолдолд _____дугаар гаалийн мэдүүлгээр гаалийн болон бусад татварт төлсөн_____төгрөг_____
_____
_____
/ татварын дүн үсгээр /
төгрөгийг төрийн сангийн тусгай данснаас улсын төсөвт үл маргах зарчмаар шилжүүлэхийг зөвшөөрч байна.

БАТАЛГАА ГАРГАСАН:

....
/Албан тушаалын нэр, /гарын үсэг/ /Албан тушаалтны нэр/
Тамга, тэмдэг/

Гааль, татварын ерөнхий газрын даргын
2016 оны А/41 дугаар тушаалын
4 дүгээр хавсралт

БАРААГ ХИЛИЙН ЧАНАДАД БУЦААН ГАРГАХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Бараг хилийн чанадад буцаан гаргах гаалийн бүрдүүлэлтийн горим / Гаалийн тухай хуулийн 132-136 дугаар зүйл, цаашид “горим” гэх /-ыг хэрэгжүүлэхэд гаалийн тухай хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.

1.2. Горим сонгох, бараг горимд байршуулах, бичиг баримт бүрдүүлэх, татвар, хураамж ногдуулах, төлөх, хураан авах, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр бараг уг горимд байршуулна.

1.4. Бараг хадгалах, барааны бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор барааны дүнд өөрчлөлт оруулахгүйгээр засвар, техникийн үйлчилгээ хийсэн нь бараг энэ горимд байршуулахаас татгалзах үндэслэл болохгүй.

Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1. Горимд гаалийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасан бараг байршуулна.

2.2. Горимд байршуулах бараанд монголын бараа хамаарахгүй.

2.3. Энэ журмын 2.1-д заасан бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарна.

2.4. Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан гадаадын бараг хилийн чанадад буцаан гаргах	300	500,508,512
2	Олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан бараг	321	507

	буцаан гаргах		
3	Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулсан гадаадын барааг хилийн чанадад буцаан гаргах:		
	-боловсруулсан, эсхүл баяжуулсан	301	501,521,531,541, 551
	- шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн	302	502,522,532,542, 552
	-засвар хийсэн	303	503,523,533,543, 553
	-бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигласан	304	504,524,534,544, 554
4	Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулсан гадаадын барааг буцаан гаргах:		
	-тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах	305	561,571,581,591
	-тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх	306	562,572,582,592
5	Гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан гадаадын барааг хилийн чанадад буцаан гаргах:		
	-гаалийн баталгаат агуулахаас	310	700,703-707,709
	- гаалийн баталгаат үйлдвэрийн газраас	311	710,712-715
	-гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас	312	720,722-725
	-гаалийн баталгаат барилгын талбайгаас	313	730-734
	- татваргүй барааны дэлгүүрээс	314	740,742,743,
	- гаалийн тусгай бүсээс	315	750-753,758-765
6	Чөлөөт бүсийн горимд байршуулсан гадаадын барааг хилийн чанадад буцаан гаргах	320	770,771,774-778
7	Улсын хилээр оруулахыг хориглосон барааг хилийн чанадад буцаан гаргах	340	шаардахгүй
8	Гаалийн бусад хяналтад байгаа барааг хилийн чанадад буцаан гаргах	350	шаардахгүй

2.5. Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимд байршуулсан гадаадын барааг боловсруулалт хийхгүй бүцаан гаргах тохиолдолд энэ горимын 305, 306 кодоор гаалийн бүрдүүлэлтийг хийнэ.

Гурав. Бичиг баримт

3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараах бичиг баримтыг шаардана.

3.1.1. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх, төлбөр тооцооны баримт;

3.1.2. тээврийн бичиг баримт / тээврийн баримт, баглаа боодлын жагсаалт, техникийн бичиг баримт гэх мэт/;

3.1.3. гарал үүслийг нотлох баримт;

3.1.4. эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, лиценз, сертификат;

3.1.5. гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх бол түүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагын баримт;

3.1.6. лабораторийн шинжилгээний дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/;

3.1.7. шаардлагатай бусад бичиг баримт.

3.2. Мэдүүлэгч 3.1-д заасан бичиг баримтыг электрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.3. Журмын 3.1-д заасан мэдээлэл, баримт бичиг нь горимын шаардлага хангаагүй бол гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.4. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Монголын гааль зөвшөөрөв” хяналтын тэмдэг дарна.

Дөрөв. Горимын шаардлага

4.1. Гаалийн тухай хуулийн 85, 93, 99 дүгээр зүйлд заасан горимын дагуу оруулсан барааг анх оруулснаас өөр боомтоор бүцаан гаргаж болно.

4.2. Хилийн чанадад бүцаан гаргах горимд байршуулах барааг анх оруулснаас өөр улс руу гаргаж болно.

4.3. Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг хугацаанд нь бүцаан гаргасан тохиолдолд түр дансанд байршуулсан импортын гаалийн болон бусад татварыг Гаалийн тариф, татварын тухай хуулийн 43 дугаар зүйлд зааснаар бүцаан олгоно.

4.4. Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулсан бараанд хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын ердийн нөхцөлд гарах элэгдэл хорогдлоос өөр бусад өөрчлөлт орсон бол урьд нь төлсөн импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгохгүй.

4.5. Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулсан барааг буцаан гаргахад Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 18.3.1-д заасан нэгж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхтэй холбогдсон зардлын тооцоо, загварын

альбом болон зарцуулсан материалын тооцоог нарийвчлан гаргаж гаалийн байгууллагаар урьдчилан хянуулсан, шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргуулсан байна.

4.6. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд барааг байршуулахаас татгалзана.

4.7. Барааг хилийн чанадад буцаан гаргах гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулсан барааг анх гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага хяналт тавьж, тусгай бүртгэл хөтлөн, хугацаа дуусахад бусад горимд шилжүүлэн гаалийн бүрдүүлэлт хийж, хаалтын мэдээг сар бүр Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох хэлтэст ирүүлнэ. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас яаралтай тодруулах зорилгоор мэдээ тайлан гаргаж өгөхийг шаардсан тохиолдолд хугацаанд нь биелүүлнэ.

Тав. Бусад

5.1. Барааг хилийн чанадад буцаан гаргах горим нь уг барааг гаалийн хилээр гаргаснаар, эсхүл өөр горимд шилжүүлснээр дуусгавар болно.

5.2. Горимд байршуулсан бараа нь гаалийн зөрчлийн улмаас саатуулагдсан, хураагдсан бол горимын үйлчлэл дуусгавар болсонд тооцно.

----oOo---